



МОНГОЛ УЛС
АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ГАЗАР

14250 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,
Сөүлийн гудамж 41, Утас: 7011-0251, Факс: (976) 7011-0251,
E-mail: comcor@iac.mn, http://iac.mn

2025.04.04 № 05/6458.
таний -ны № -т

ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН ТӨВ
ТӨРИЙН ӨМЧИТ ҮЙЛДВЭРИЙН
ГАЗРЫН ЗАХИРАЛ Д.ОЮУНБОЛД
ТАНАА

Хувийн ашиг сонирхлын урьдчилсан
мэдүүлгийг хянасан тухай

“Зам, тээврийн хөгжлийн төв” ТӨҮГ-ын Төлбөр авах үйл ажиллагааны хэлтсийн тооцооны нягтлан бодогчийн албан тушаалд томилогдоо нэр дэвшсэн Баасанжавын Батсүхийн хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийг Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.6 дахь хэсэгт заасныг үндэслэн хянахад ашиг сонирхлын зөрчил үүсэх нөхцөл байдал одоогоор тогтоогдоогүй болно.

Б.Батсүх нь гадаад худалдаа, барилгын засвар үйлчилгээ эрхлэх “Сономбюлдинг” ХХК, “Петровиллаже монголия” ХХК-ийн үүсгэн байгуулагч, хувь эзэмшигч, гүйцэтгэх захирлаар тус тус бүртгэл байх тул дээрх хуулийн 19, 20 дугаар зүйлд заасан хориглолт, хязгаарлалтыг хэрэгжүүлэн ажиллах нь зүйтэй.

Нэр дэвшигч нь тухайн албан тушаалд томилогдсон тохиолдолд Авлигын эсрэг хуулийн 10 дугаар зүйлийн 10.3, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.3 дахь хэсэгт заасан хугацаанд хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө орлогын мэдүүлэг, тухайн албан үүргийг гүйцэтгэхэд ашиг сонирхлын зөрчил үүссэн, үүсэж болзошгүй нөхцөл байдалд дээрх хуулийн 8 дугаар зүйлд заасан мэдэгдэл, тайлбарыг тухай бүр гаргаж байх, мөн хуульд заасан хориглолт, хязгаарлалтыг хэрэгжүүлж ажиллахад анхаарна уу.

ХЯНАЛТ ШАЛГАЛТ,
ДҮН ШИНЖИЛГЭЭНИЙ ХЭЛТСИЙН ДАРГА,
ЭРХЭЛСЭН КОМИССАР

Т.ЭНХБОЛД



142503007539